


БАТЛАВ.
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

№

2022/152

2022 оны 07 сарын 05 өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г Монгол улсын Иргэний хуулийн 32 дугаар бүлгийг үндэслэн нэг талаас Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрыг төлөөлж Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг /цаашид "Захиалагч" гэнэ/, нөгөө талаас Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо ТББ-ын тэргүүн О.Хосбаяр /цаашид "Зөвлөх" гэнэ/ хамтад нь /"Талууд" гэнэ/ нар харилцан тохиролцож байгуулав.

1.2. "Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох яам, агентлагаас ирүүлсэн саналын дагуу засварлах, саналын товъёог үйлдэх үйлчилгээ үзүүлэх, Захиалагч ажлын хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.

1.3. Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд зөвлөх нь 2022 оны 08 дугаар сарын 25-нд хуулийн төсөл, саналын товъёогийг /засварласан баримтаа/ хүлээлгэн өгч, захиалагч сүүлийн санхүүжилтийг хийснээр гэрээ дуусгавар болно.

1.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагчийн эрх, үүрэг:

- 2.1. Зөвлөхийг гэрээний үүргээ биелүүлэх нөхцлөөр хангах.
- 2.2. Гэрээгээр тохирсон хөлсийг Зөвлөхөд олгох.
- 2.3. Хуулийн төсөл, саналын товъёогийг ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор шалгаж, актаар хүлээн авах бөгөөд ажил хүлээлгэн өгсөн актыг үндэслэн санхүүжилтийг хийх.
- 2.4. Гэрээгээр хүлээх үүргээ хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг шаардах.
- 2.5. Захиалагч нь Зөвлөх хуулийн төсөл, саналын товъёогийг гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээг дангаараа цуцлах эрхтэй.

Зөвлөхийн эрх, үүрэг:

2.7. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах хууль, саналыг холбогдох хууль журамд нийцүүлэн тусган, засварлан, саналын товъёог үйлдэх:

- а. УИХ-ын 2022.06.17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль.
- б. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал.
- с. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн санал.

2.8. Хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоо хангагдсан эсэхийг хянаж, засварлах.

2.9. 2021-2022 онд хуулийн төсөлд бусад яам, агентлагаас ирүүлсэн саналыг хуульд тусгасан эсэх, саналын товъёогийг бүрэн эсэхийг хянах, засварыг оруулах.

2.10. Засгийн газарт өргөн барих хуулийн төслийн баримтын бүрдэл хангагдсан эсэхийг хянах, шаардлагатай баримтын жагсаалтыг гаргах.

2.11. Дараах баримтыг гэрээт ажлын хугацааг дуусгахад хүлээлгэн өгнө:

- а. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
- б. Хуулийн төсөлд өгсөн байгууллагуудын саналыг тусгасан эсэх саналын товъёог.
- с. Засгийн газар, УИХ-д өргөн барих баримт бичгийн дутуу хэсгийн жагсаалт.

2.12. Засвар, өөрчлөлт орж байгаа хэсэг, заалтуудыг БХБЯ болон ГЗБГЗЗГ-ын холбогдох албан тушаалтнуудтай зөвшилцөх.

2.13. Гэрээгээр тохиролцсон ажлын хөлсөө авах.

2.14. Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол үнэ төлбөргүйгээр нөхөн гүйцэтгэх.

2.15. Захиалгат ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги төлөх.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. АЖЛЫН ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ, ХЭЛБЭР, ОЛГОХ ЖУРАМ

3.1. Зөвлөх үйлчилгээний хөлсөнд 6000000 /зургаан сая/ төгрөгийг ажлаа бүрэн хүлээлгэн өгч, Захиалагч хуулийн төслийн баримтын бүрдлийг шалгаж, актаар хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД

4.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр 1 хувийг хадгална.

4.3 Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Энэ гэрээгээр зохицуулаагүй харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

4.4 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗУХАГ-ын дарга

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МГФЗЗХ-ны тэргүүн

Р.Ганхуяг

ГЗЗХ-ийн дарга

Д.Мөнхцэцэг

СЭЗХ-ийн дарга

Л.Лувсан

Захиалагчийн хаяг: Чингэлтэй дүүрэг,
2-р хороо, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын 12-р байр, 215 тоот
Утас: 262381, 261217, 260546
Харилцагч банкны нэр: Төрийн сан Төв
Дансны дугаар: 900028002



О.Хосбаяр

Зөвлөхийн хаяг:

Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Их тойруу 15,
Ренталон ХХК-ийн байр, 424 тоот
Утас: 99088235
Харилцагч банкны нэр: Хаан банк
Дансны дугаар: 5175096762